

**Бохир усны станцыг бүрэн автоматжуулж
алсын удирдлагад шилжүүлэх
ҮНИЙН САНАЛ АВАХ ЖИШИГ БАРИМТ
БИЧИГ**

Харьцуулалтын аргаар:

Захиалагч: Дулаан Шарын гол ТӨХК
Гэрээний нэр: Бохир усны станцыг бүрэн автоматжуулж алсын
удирдлагад шилжүүлэх
Гэрээний дугаар: ДШГ/201902010
Байгууллагын код: ДШГ

ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨХК
Дархан-Уул аймаг Шарын гол сум
2019 он

ОРШИЛ

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас боловсруулсан энэхүү үнийн санал авах жишиг баримт бичгийг Захиалагч байгууллага 80'000'000 хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад мөрдөнө.

Үнийн санал авах жишиг бичиг баримтын заалтуудад зарчмын бус өөрчлөлт оруулж тухайн ажлыг худалдан авах ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлбэл зохино. Эдгээр өөрчлөлтийг хийхдээ дараах удирдамжийг дагаж мөрдөнө.

1. Үнийн санал авах баримт бичгийг худалдан авах ажил буюу төслийн онцлог байдалд нийцүүлэн энэхүү жишиг баримт бичгийн дагуу бэлтгэнэ.
2. Захиалагч тендерийн баримт бичгийг бэлтгэхдээ налуу үсгээр хаалтанд бичсэн жишээ, зааврын оронд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ, хувь зэргийг бөглөнө. Тендерт оролцогчийн бөглөх хэсгийг захиалагч бөглөхгүй орхино.
3. Үнийн санал авах жишиг баримт бичгийн зүүлт/тайлбар болон санамж нь захиалагчид заавар өгөх зорилготой тул үнийн санал авах баримт бичгийг бэлтгэхдээ тэдгээрийг хасна.

Энэхүү тендерийн баримт бичигтэй холбоотой асуулт ирүүлэх, тайлбар эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбоо барина уу.

Web: WWW.TENDER.GOV.MN

Нэг: УРИЛГА

Тендер зарлах хугацаа: 2019-03-22

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дулаан Шарын гол ТӨХК нь тендерт оролцогчдоос **Бохир усны станцыг бүрэн автоматжуулж алсын удирдлагад шилжүүлэх** тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг WWW.TENDER.GOV.MN сайт дээр тавьсан болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Үнийн саналыг 2018-04-01-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө WWW.TENDER.GOV.MN сайтад байршуулсан байна.

Тендерийн нээх хугацаа 2018-04-01 өдөр 11 цаг 30 минут

Тендерт оролцогчдод дотоодын давуу эрх тооцохгүй.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана. ААНБ-н улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, татварын тодорхойлолт
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан

тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
 - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
 - 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
 - 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; 2. Санхүүгийн аудитлагдсан тайлан 3. Үнийн санал ирүүлэхээс өмнө газар дээр ирж хийгдэх ажилтай танилцсан байх шаардлагатай. 4. Борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй 5. Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн наториатаар баталгаажуулсан хуулбар 6. Татвар, нийгмийн даатгалын тодорхойлолт 7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 8. Шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, ажил гүйцэтгэх хуваарь, зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгэх хүлээлгэн өгөх талаар албан мэдэгдэл ирүүлэх <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Хайрхан баг Дулаан Шарын гол ТӨХК-ний байр Н.Баттулга 99174111</p> <p>Огноо: <i>2019 оны 4 дүгээр сарын 01-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>11 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Хайрхан баг Дулаан Шарын гол ТӨХК-ний байр</p> <p>Огноо: <i>2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>11 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: Бохир усны станцыг бүрэн автоматжуулж алсын удирдлагад шилжүүлэх, ДШГ/201902010</p>



БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЭНХЦЭЦЭГ

ДАРХАН УУЛ АЙМАГ "ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨХК-ИЙН БОХИР УС ТАТАН
ЗАЙЛУУЛАХ НАСОС СТАНЦ, ДУЛААН ДАМЖУУЛАХ ТӨВИЙГ АВТОМАТ СИСТЕМД
ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Захиалагч байгууллага: "Дулаан Шарын гол" ТӨХК

Ажлын зорилго: Дархан-уул аймаг Шарын гол сумын бохир ус татан зайлуулах Насос станц, Дулаан дамжуулах төвийн автоматжуулалтын тоног төхөөрөмжийн угсралтыг БНБД ба Монгол улсын стандартын дагуу гүйцэтгэнэ.

1. Бохир ус татан зайлуулах насос станц

- Бохир ус өргөх насос 001 нь насос станцын /КНС/-ын бохир ус цуглуулах Танк №-001 санд цугларсан бохир усны түвшинг мэдрэх ультрасоник түвшин хэмжигчийн дохиолоолоор автоматаар ажиллана. Бохир ус цуглуулах Танк №-001-ийн түвшин дуусахад автоматаар зогсох ба алсын зайн скада системээс удирдах хянах боломжтой мөн байрнаас гар удирдлагаар удирдах боломжтой байхаар удирдлагын самбар нь гүйцэтгэгдсэн байна.
- Бохир ус өргөх насос 002 нь насос станцын /КНС/-ын бохир ус цуглуулах Танк №-001 санд цугларсан бохир усны түвшинг мэдрэх ультрасоник түвшин хэмжигчийн дохиолоолоор автоматаар ажиллана. Бохир ус цуглуулах Танк №-001-ийн түвшин дуусахад автоматаар зогсох ба алсын зайн скада системээс удирдах хянах боломжтой мөн байрнаас гар удирдлагаар удирдах боломжтой байхаар удирдлагын самбар нь гүйцэтгэгдсэн байна.
- Бохир ус өргөх насос 003 нь насос станцын /КНС/-ын бохир ус цуглуулах Танк №-001 санд цугларсан бохир усны түвшинг мэдрэх ультрасоник түвшин хэмжигчийн дохиолоолоор автоматаар ажиллана. Бохир ус цуглуулах Танк №-001-ийн түвшин дуусахад автоматаар зогсох ба алсын зайн скада системээс удирдах хянах боломжтой мөн байрнаас гар удирдлагаар удирдах боломжтой байхаар удирдлагын самбар нь гүйцэтгэгдсэн байна.
- Бохир усны насосны илүүдэлд цугларсан бохир усны түвшинг мэдрэх ультрасоник түвшин хэмжигчийн дохиолоолоор автоматаар сорж шахах. Алсын зайн скада системээс удирдах хянах боломжтой мөн байрнаас гар удирдлагаар удирдах боломжтой байхаар удирдлагын самбар нь гүйцэтгэгдсэн байна.

2. Дулаан дамжуулах төвийн хүйтэн ус, хэрэгцээний халуун ус, сүлжээний усны параметруудийг алсын зайн скада системээр хянах боломжтой болох:

Одоо байгаа бохир ус өргөх насос тоног төхөөрөмжүүд

Бохир ус өргөх насос станцын системд одоо байгаа насос тоног, төхөөрөмжүүд . Үүнд

Хүснэгт-1 насосны марк үзүүлэлт

№	Насосны марк, дугаар	Насосны хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1.	Өргөлтийн насос-001-003 марк. СД160-45. Q=160м ³ /h. H=45м. N=37Квт	Waste water pump, СД160-45, Q=160m ³ /hour, H=45m, N=37kW	pcs	3
2.	Цахилгаан тоолуур-001-002, марк: XL005BJ-YJFS. Q= 10/h. N=7.5Кв	Electri magnetic flowmeter, XL005BJ-YJFS, Q= 10m ³ /hour, N=7.5kW	pcs	4

Гэрээлэгч нь энэхүү даалгаврын хүрээнд насос станцын байгууламжинд зориулж дээрх тоног төхөөрөмжийг ханган нийлүүлж удирдлага хяналтын самбарын угсралтын ажил, Дулаан дамжуулах төвийн хяналтын самбар угсралтын ажлыг тус тус хийж гүйцэтгэнэ.

3. Цахилгаан удирдлага, хяналтын тоног, төхөөрөмж:

Төрөл

Бохир усны өргөлтийн насос, удирдлага хяналтын самбар, теле хяналтын систем. Дулаан дамжуулах төвийн хяналтын самбар, теле хяналтын систем.

Ханган нийлүүлэгчийн хангах хяналтууд

- Насос эвдрэл, гэмтэл гарсан үед зогсоох;
- Бохир ус цуглуулах сангийн түвшин доошлож, хуурай явалтаас хамгаалагдах;
- Өөрийн урсгалтай DN 300 хаалт автоматжуулж бохирын усан сангийн түвшин халихаас сэргийлж хааж байх .
- Насос ажиллаж эхлэхэд насосыг автоматаар эзлжлэн ажиллуулах боломжтой,
- Даралт мэдрэгчээс мэдээллийг авч даралтыг тогтвортой барих - системийн автомат ажиллагааг удирдах;
- Зарцуулга хэмжигчээс мэдээлэл авах боломжтой,
- Шугамын даралт буурахад насосыг унтраах;
- Моторыг хэт халалтаас хамгаалах;
- Изоляци зөвшөөрөгдөх хэмжээнээс их болох,
- Цахилгааны хүчдэл хэт ихсэх, эсвэл хэт багасах,
- Гүйдлийн хүч хэт ихсэх, хэт багасах,
- Цахилгааны фазын дараалал алдагдах, фаз дутуу,
- Цахилгааны фаз хоорондын зөрүү зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэх,
- Гар ажиллагаатай байх;
- Бохир усны насосны илүүдэлийг хянах
- Хүчдэл тасарсан үед аварийн хаалт автоматаар хаагдах

**Ханган
нийлүүлэгчийн
хангах
дохиоллууд**

- a) Урсац байхгүй;
- b) Насос гэмтсэн;
- c) Моторын хэт халалт;
- d) Кабелын изоляци;
- e) Цахилгааны хүчдэл хэт ихсэх, эсвэл хэт багасах;
- f) Гүйдлийн хүч хэт ихсэх, хэт багасах;
- g) Цахилгааны фазын дараалал алдагдах;
- h) Цахилгааны фаз хоорондын зөрөө зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэх;

**Удирдлагын тоног
төхөөрөмж,
дэлгэц**

- a) Шахах талын түвшин – ХИ, ХБ утганд насос зогсох,
- b) Сорох талын түвшин -ХИ, ХБ утганд насос зогсох,
- c) Сорох талын (хуурай явалтаас хамгаалах) – түвшиний датчик
- d) Амперметр – самбар, насосны гүйдлийн утгыг харуулах;
- e) Вольтметр – насос, самбарт ирж буй тэжээлийн хүчдэлийн утгыг харуулах;

**Ханган
нийлүүлэгчээс
хангах оролт,
гаралт**

- a) DI – 1 pcs, Pump Stop; LL сорох талын түвшингийн датчик
- b) DI-1 pcs шахах талын даралтын датчикийн дээд утга насос зогсох;
- c) AI – 1 pcs (4 – 20 mA), скада системд шахах талын даралтын датчкын мэдээлэл;
- d) DI – 2 pcs Усан сангийн ХБ түвшин насос зогсох;

**Ханган
нийлүүлэгчийн
хангах дагалдах
хэрэгсэлүүд**

Насосны тоног төхөөрөмжийг угсрах гарын авлага болон бусад техникийн баримт бичиг дагалдуулж, холбогдох мэргэжилтэй ажилчдад ашиглалтын талаар сургалт зохион байгуулах.

**Насосны
удирдлагын
самбар**

380 вольтийн хүчдэл, ажиллах давтамж 50 Гц
Насосны хамгийн их эргэлт: 1450 эрг/мин
Хамгаалалтын ангилал: IP 55
Асаалтын схем: "шууд"
Тусгаарлалтын ангилал: "F"
Асаалтын зөвшөөрөгдөх тоо: Цагт 30 хүртэл, хоногт 300 хүртэл,
Халалтын хамгаалалт: Дулаан мэдрэгч

**Халаалтын
системийн хяналт**

Насос станцын халаалтын системийн оролт гаралт тус бүрийн даралт, температурын хяналт, машин заал болон операторын өрөөний температурыг Удирдлага хяналтын дэлгэцэнд хянах.

**Чанарын
туршилт,
баталгаажуулалт**

Тоног төхөөрөмж үйлдвэрлэгч нь ISO чанарын стандартын шаардлагыг хангасан байх бөгөөд чанарын стандартын хуулбарыг техникийн саналдаа хавсарган ирүүлнэ. Тоног төхөөрөмж үйлдвэрлэгч нь сүүлийн 5 жил уг үйлдвэрлэсэн туршлагатай байх.

**Автомат
удирдлага
болон Теле
хяналтын систем**

Бохир усны насос тоног төхөөрөмжийн ажиллагаа болон Удирдлагын системийг гүйцэтгэхдээ бүх системийг Скада систем бүхий компьютерээр хянах болон удирдах байдлаар гүйцэтгэх. Насосны станцаас ирэх мэдээллийг шилэн кабелийн тусламжтайгаар компанийн оффист байрлах Скада систем бүхий компьютертэй холбож өгнө. Мөн теле хянатын камерийн хяналтыг удирдлагын өрөөнд шилэн кабелийн тусламжтайгаар хүлээж авна. Ингэснээр уг удирдлагын системээс бохир усны насос станцын тоног төхөрөөмжийг ажиллуулах болон зогсоох командыг өгнө. Мөн тухайн станцын төлөв ямар байгааг мэдэх боломжтой болно. Хяналтын дэлгэц, компьютерийг операторын өрөөнд суурилуулж өгнө.

Дулаан дамжуулах төвийн хүйтэн ус, хэрэгцээний халуун ус, сүлжээний усны даралт температур зарцуулалтыг алсын зайн скада системээр хянах боломжтой болох:

Хянасан

Ерөнхий инженер



Л.Нарангэрэл

Ажлын даалгавар боловсруулсан:

УДАТХ-ийн ашиглалтын инженер



Д.Нямцэрэн

УДАТХ-ийн механик



Б.Сархад

ХНСХМ



Д.Урангуа

"Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Скада болон хяналтын системийн материалын түүвэр

д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо
Насосны удирдлагын самбар		
1	Самбарын хайрцаг	1
2	Дижитал ампер, вольтметр	1
3	Завсрын реле	2
4	Автомат таслуур 400А	1
5	Цахилгаан соронзон залгуур 95А	6
6	Мотор starter 100А	3
7	Гүйдлийн трансформатор	3
8	Амперметр сэлгэн	1
9	Вольтметр сэлгэн	1
10	Хүчний хэлхээний утас 35мм ²	50
11	Удирдлагын хэлхээний утас 1.5мм ²	30
12	Индикатор гэрэл	9
13	Этавилт түлхүүр	4
14	Emergency товчлууур	1
15	Тоноглол түгжигч	20
16	Удирдлагын клем	8
17	Төгсгөвч	1
18	Нейтралын клем	1
19	Газрын клем	4
20	Хүчний клем	9
21	Зам төмөр	3
22	Кориток	5
23	Марклагч	20
Скада тоног төхөөрөмж		
1	PLC (ABB PM564)	1
2	PLC самбар 500*600*210	1
3	SCADA software	1
4	Analog Input modul AI561	4
5	Digital Output modul DI562	2
6	Хэмжүүрийн кабель	500
7	PVC хоолой	200
8	Server	1
9	Switch	1
10	Хяналтын дэлгэц 40"	1
11	Хэрэглэгчийн компьютер Dell	1
12	Даралт мэдрэгч	10
13	Ультра түвшин мэдрэгч	1
14	Температур мэдрэгч /халаалтын шугам/	6
15	Температур мэдрэгч /өрөөний /	3
16	Цахилгаан хаалт Dn 15	2
17	Даралтын хэмжүүрийн кабель	15
18	Температурын хэмжүүрийн кабель	15
19	Зарцуулгын хэмжүүрийн кабель	15
20	Түвшиний хэмжүүрийн кабель	15
Теле хяналтын төхөөрөмж		

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 2.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 3. Бараа нийлүүлэх | 3.1. Техникийн тодорхойлолт дээр нэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн стандарт, шаардлагад нийцээгүй тохиолдолд захиалагч шаардлага тавьж, авахаас татгалзах, шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнээр солулах эрхтэй |
| 4. Маргааныг шийдвэрлэх | 4.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 5. Ажлын хөтөлбөр | 5.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.
5.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежер хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 6. Зөрчил, гологдол илрүүлэх | 6.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 7. Зөрчил, гологдол арилгах | 7.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
7.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 8. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 8.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------|--|
| 9. Үе шатны | 9.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны |
|-------------|--|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

ажлын хуваарь	ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
	9.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
10. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх	10.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
11. Алданги	11.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

12. Ажил дуусгах	12.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.
13. Гэрээг цуцлах	13.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй. 13.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй: (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон; (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан; (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй; (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
14. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	14.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

**15. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

15.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 1.1	Барилгын угсралтын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх
ГЕН 2.1	Ажил эхлэх <i>2019он</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн 2019 он
ГЕН 3.1	Чанарын баталгаат хугацаа <i>3 жил</i> байна.
ГЕН 4.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[0,2%]</i> байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.

3 Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

4 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20... онд: _____ төгрөг; 20... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт ____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, ____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;

- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]